УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Өндөрхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: УВА-2026/026/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас:70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Шүрт хайрханы хишиг аудит ХХК-ийн Аудитор: С.Батсайхан<br>Утас: 99163087, Цахим хаяг: shurtkhairkhaniikhishigaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8
2.5.1Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Улсын төсөв ..... 11
2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Орон нутгийн төсөв ..... 11
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..... 13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..... 13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 14
3.5.1 Төсвийн төлөвлөлт ..... 14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл ..... 14
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ..... 17
4.1 Ерөнхий зүйл ..... 17
4.2 Материаллаг байдал ..... 17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 18
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ..... 18
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 19
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум, Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn


2026.02.15 № УВА-2026/026/НА-СТА-ТЦ3
танай ______ -ны № ______ -т

ӨНДӨРХАНГАЙ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Ч.ЭНХТУЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өндөрхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Өндөрхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050164

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

9065555 1525010041

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

**2.1.Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан** **/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **150,475,206.13** | **141,568,898.73** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 12,024,476.49 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 12,024,476.49 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 12,024,476.49 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 12,024,476.49 |
| **33** | **АВЛАГА** | 75,837,312.34 | 23,063,014.85 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 500,000.00 | 500,000.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 75,337,312.34 | 22,563,014.85 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 74,637,893.79 | 106,481,407.39 |
| **351** | **Түүхий эд материал** | 35,242,862.26 | 51,966,195.26 |
| 35130 | Эм боох материал | 35,242,862.26 | 51,966,195.26 |
| **354** | **Хангамжийн материал** | 39,395,031.53 | 54,515,212.13 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 445,940.00 | 00.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 19,928,960.33 | 22,817,951.93 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 2,509,000.00 | 5,399,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 14,452,070.00 | 23,081,030.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,059,061.20 | 3,217,230.20 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **551,530,494.94** | **646,942,345.30** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 551,530,494.94 | 646,942,345.30 |
| **392** | **Биет хөрөнгө** | 536,019,494.94 | 631,506,345.30 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 506,386,680.75 | 506,386,680.75 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -175,381,187.17 | -182,533,532.41 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 134,045,844.43 | 311,025,844.43 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -65,112,186.05 | -103,961,354.87 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 365,339,796.44 | 396,330,126.54 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -250,261,821.05 | -311,238,418.84 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 50,575,400.00 | 50,575,400.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -29,573,032.41 | -35,078,400.30 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 15,511,000.00 | 15,436,000.00 |
| 39301 | Програм хангамж | 740,000.00 | 740,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -665,000.00 | -740,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 15,436,000.00 | 15,436,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **702,005,701.07** | **788,511,244.03** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **63,345,883.42** | **19,327,221.40** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 63,345,883.42 | 19,327,221.40 |
| **413** | **Өглөг** | 63,345,883.42 | 19,327,221.40 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 29,593,052.42 | 780,853.80 |
| **4136** | **Бусад өглөг** | 33,752,831.00 | 18,546,367.60 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 33,752,831.00 | 18,546,367.60 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **638,659,817.65** | **769,184,022.63** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 638,659,817.65 | 769,184,022.63 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 643,204,474.00 | 643,204,474.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 643,204,474.00 | 643,204,474.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -206,676,666.62 | -76,152,461.64 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -206,676,666.62 | -206,676,666.62 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 130,524,204.98 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 202,132,010.27 | 202,132,010.27 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **702,005,701.07** | **788,511,244.03** |
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **150,475,206.13** | **141,568,898.73** |

**2.2.Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** **/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,269,497,413.48** | **1,418,440,353.60** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **121,188,013.83** | **217,721,060.10** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 121,188,013.83 | 217,721,060.10 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 115,533,569.83 | 215,530,730.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 130,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 11,390,730.00 |
| 120005 | Түрээсийн орлого | 3,654,444.00 | 2,190,330.10 |
| 120009 | Бусад орлого | 2,000,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,148,309,399.65** | **1,200,719,293.50** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 56,158,200.00 | 42,181,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 56,158,200.00 | 42,181,400.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,092,151,199.65 | 1,158,537,893.50 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,092,151,199.65 | 1,158,537,893.50 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,184,961,309.35** | **1,287,916,148.62** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,184,961,309.35** | **1,287,916,148.62** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,183,273,712.60 | 1,283,653,748.57 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 770,702,232.94 | 872,828,422.23 |
| 210101 | Үндсэн цалин | 486,628,671.00 | 542,770,285.43 |
| 210102 | Нэмэгдэл | 255,393,761.94 | 286,986,106.80 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,840,000.00 | 6,651,400.00 |
| 210104 | Урамшуулал | 21,839,800.00 | 36,420,630.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 97,415,722.71 | 108,038,666.15 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 66,536,807.47 | 73,235,294.32 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,638,343.68 | 8,599,844.57 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,757,222.98 | 4,671,770.98 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,788,197.38 | 4,299,922.24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,695,151.20 | 17,231,834.04 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 52,718,153.25 | 54,241,865.55 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,368,538.07 | 5,278,463.95 |
| 210302 | Түлш, халаалт | 48,349,615.18 | 48,663,401.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 300,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 52,697,994.73 | 54,276,298.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,844,549.00 | 1,998,740.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,875,800.00 | 31,193,380.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,412,000.00 | 990,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,064,000.00 | 500,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,501,645.73 | 19,594,178.40 |
| **2105** | **Нормативт зардал** | 105,726,552.84 | 70,521,912.50 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 89,341,002.84 | 57,875,030.50 |
| 210502 | Хоол, хүнс | 14,885,550.00 | 12,646,882.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,500,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,558,000.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,835,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 9,723,000.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,608,000.00 | 7,950,300.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 00.00 | 64,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,608,000.00 | 7,886,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,588,058.00 | 2,281,204.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 538,000.00 | 435,464.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | 806,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 200,925.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 262,773.00 | 350,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.00 | 677,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 154,360.00 | 12,340.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 80,258,998.13 | 113,515,079.74 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,249,800.00 | 956,600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 77,009,198.13 | 112,558,479.74 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,687,596.75 | 4,262,400.05 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,687,596.75 | 4,262,400.05 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,687,596.75 | 4,262,400.05 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **84,536,104.13** | **130,524,204.98** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **84,536,104.13** | **130,524,204.98** |

**2.3.Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** **/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,086,033,876.31** | **1,257,923,590.99** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,000,000.00** | **4,430,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,000,000.00 | 4,430,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 4,430,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 130,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 4,300,000.00 |
| 120009 | Бусад орлого | 2,000,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,084,033,876.31** | **1,253,493,590.99** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 56,158,200.00 | 42,181,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 56,158,200.00 | 42,181,400.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,027,875,676.31 | 1,211,312,190.99 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,027,875,676.31 | 1,211,312,190.99 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,086,033,876.31** | **1,245,899,114.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,086,033,876.31** | **1,245,899,114.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,084,346,279.56** | **1,241,636,714.45** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 752,638,128.43 | 880,788,181.90 |
| 210101 | Үндсэн цалин | 434,502,379.98 | 488,273,759.03 |
| 210102 | Нэмэгдэл | 289,297,511.13 | 310,711,197.14 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,903,209.45 | 6,631,400.00 |
| 210104 | Урамшуулал | 21,935,027.87 | 75,171,825.73 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 88,485,611.78 | 128,891,105.10 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,198,483.46 | 97,643,842.08 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,259,397.79 | 7,797,199.98 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,227,818.31 | 3,958,213.09 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,031,479.48 | 3,898,349.99 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,768,432.74 | 15,593,499.96 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 52,970,603.25 | 37,918,999.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,620,988.07 | 5,278,463.95 |
| 210302 | Түлш, халаалт | 48,349,615.18 | 32,340,536.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 300,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 71,255,769.00 | 53,851,640.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,374,649.00 | 1,454,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 48,749,610.00 | 39,668,340.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,412,000.00 | 990,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,919,510.00 | 1,767,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 14,800,000.00 | 9,970,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 92,401,909.10 | 120,590,183.50 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 74,728,159.10 | 101,324,133.50 |
| 210502 | Хоол, хүнс | 15,423,750.00 | 15,066,050.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,250,000.00 | 4,200,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,800,000.00 | 8,494,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,000,000.00 | 2,000,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,800,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,000,000.00 | 6,494,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,608,000.00 | 7,950,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,608,000.00 | 7,950,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,593,058.00 | 2,281,204.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 538,000.00 | 435,464.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | 806,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 200,925.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 267,773.00 | 350,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.00 | 677,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 154,360.00 | 12,340.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,593,200.00 | 871,100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,593,200.00 | 871,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,687,596.75** | **4,262,400.05** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,687,596.75 | 4,262,400.05 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,687,596.75 | 4,262,400.05 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **12,024,476.49** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 12,024,476.49 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 12,024,476.49 |

**2.4.Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** **/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 643,204,474.00 | 202,604,526.27 | -315,234,545.44 | 530,574,454.83 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 184,912.00 | 184,912.00 |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **643,204,474.00** | **202,604,526.27** | **-315,049,633.44** | 530,759,366.83 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 5 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 84,536,104.13 | 84,536,104.13 |
| 8 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **643,204,474.00** | **202,132,010.27** | **-206,676,666.62** | 638,659,817.65 |
| 9 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **643,204,474.00** | **202,132,010.27** | **-206,676,666.62** | 638,659,817.65 |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 11 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **643,204,474.00** | **202,132,010.27** | **-206,676,666.62** | 638,659,817.65 |
| 12 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 13 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 14 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 15 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 16 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 130,524,204.98 | 130,524,204.98 |
| 17 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **643,204,474.00** | **202,132,010.27** | **-76,152,461.64** | 769,184,022.63 |

**2.5.1.Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Улсын төсөв /төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,246,860,700.0** | **1,203,717,714.5** | **43,142,985.5** | **96.6** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,246,860,700.0** | **1,203,717,714.5** | **43,142,985.5** | **96.6** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,246,860,700.0** | **1,203,717,714.5** | **43,142,985.5** | **96.6** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **882,027,000.0** | **880,788,181.9** | **1,238,818.1** | **99.9** |
| 210101 | Үндсэн цалин | 565,225,100.0 | 488,273,759.0 | 76,951,341.0 | 86.4 |
| 210102 | Нэмэгдэл | 235,447,500.0 | 310,711,197.1 | (75,263,697.1) | 132.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,356,400.0 | 6,631,400.0 | 1,725,000.0 | 79.4 |
| 210104 | Урамшуулал | 72,998,000.0 | 75,171,825.7 | (2,173,825.7) | 103.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **139,440,500.0** | **128,891,105.1** | **10,549,394.9** | **92.4** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 105,334,200.0 | 97,643,842.1 | 7,690,357.9 | 92.7 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,526,600.0 | 7,797,200.0 | 729,400.0 | 91.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,263,300.0 | 3,958,213.1 | 305,086.9 | 92.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,263,300.0 | 3,898,350.0 | 364,950.0 | 91.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,053,100.0 | 15,593,500.0 | 1,459,600.0 | 91.4 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **59,618,700.0** | **53,851,640.0** | **5,767,060.0** | **90.3** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,574,700.0 | 1,454,900.0 | 119,800.0 | 92.4 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 43,000,000.0 | 39,668,340.0 | 3,331,660.0 | 92.3 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,034,000.0 | 990,000.0 | 44,000.0 | 95.7 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,920,000.0 | 1,767,500.0 | 152,500.0 | 92.1 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,090,000.0 | 9,970,900.0 | 2,119,100.0 | 82.5 |
| **2105** | **Нормативт зардал** | **121,695,200.0** | **120,590,183.5** | **1,105,016.5** | **99.1** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 101,796,100.0 | 101,324,133.5 | 471,966.5 | 99.5 |
| 210502 | Хоол, хүнс | 15,649,100.0 | 15,066,050.0 | 583,050.0 | 96.3 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,250,000.0 | 4,200,000.0 | 50,000.0 | 98.8 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **29,300,000.0** | **8,494,000.0** | **20,806,000.0** | **29.0** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 18,000,000.0 | 2,000,000.0 | 16,000,000.0 | 11.1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,800,000.0 | - | 1,800,000.0 | - |
| 210604 | Урсгал засвар | 9,500,000.0 | 6,494,000.0 | 3,006,000.0 | 68.4 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **9,445,600.0** | **7,950,300.0** | **1,495,300.0** | **84.2** |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,445,600.0 | 7,950,300.0 | 1,495,300.0 | 84.2 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,240,500.0** | **2,281,204.0** | **1,959,296.0** | **53.8** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 583,100.0 | 435,464.0 | 147,636.0 | 74.7 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 806,400.0 | 806,400.0 | - | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 500,000.0 | - | 500,000.0 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 350,000.0 | 350,000.0 | - | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 150,000.0 | - | 150,000.0 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,551,000.0 | 677,000.0 | 874,000.0 | 43.6 |
| 210807 | Газрын төлбөр | 300,000.0 | 12,340.0 | 287,660.0 | 4.1 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,093,200.0** | **871,100.0** | **222,100.0** | **79.7** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,093,200.0 | 871,100.0 | 222,100.0 | 79.7 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,246,860,700.0** | **1,215,742,190.99** | **31,118,509.01** | **90.5** |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,242,860,700.0** | **1,211,612,190.99** | **31,118,509.01** | **102.9** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,242,860,700.0 | 1,211,612,190.99 | **31,118,509.01** | 102.9 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **4,000,000.0** | **4,130,000.0** | **(130,000.0)** | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 130,000.0 | (130,000.0) | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,000,000.0 | 4,000,000.0 | | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** | **-** | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **12,024,476.5** | **(12,024,476.5)** | |

**2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /орон нутгийн төсөв/**

| 10 | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **42,181,400.0** | **37,918,999.95** | **4,262,400.05** | **89.9** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **42,181,400.0** | **37,918,999.95** | **4,262,400.05** | **89.9** |
| **210** | **Бараа, үйлчилгээний зардал** | **42,181,400.0** | **37,918,999.95** | **4,262,400.05** | **89.9** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **38,581,400.0** | **37,918,999.95** | **662,400.05** | **98.2** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,554,900.00 | 5,278,463.95 | 1,276,436.05 | 80.5 |
| 210302 | Түлш, халаалт | 31,064,100.00 | 32,340,536.0 | -1,276,436.0 | 104.1 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 962,400.0 | 300,000.0 | 662,400.0 | 31.2 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,600,000.0** | **0.0** | **3,006,000.0** | **83.5** |
| 210604 | Урсгал засвар | 3,600,000.0 | 0.0 | 3,600,000.0 | **83.5** |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **42,181,400.0** | **37,918,999.95** | **4,262,400.05** | **98.53** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **42,181,400.0** | **37,918,999.95** | **4,262,400.05** | **98.53** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 42,181,400.0 | 37,918,999.95 | 4,262,400.05 | 98.53 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өндөрхангай сумын Эрүүл мэндийн төв нь хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх орон нутгийн өмчит хуулийн этгээд байх бөгөөд байршил, хүн амын төвлөрөл, өвчлөл, осол гэмтлийн нөхцөл байдлаас хамааран яаралтай тусламж, үйлчилгээний болон багийн эмчийн салбартай байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өндөрхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон, шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өндөрхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 61,752.20 мянган төгрөгөөр буюу 1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 12,024.48 | 12,024.48 |
| Авлага | 75,837.31 | 500.0 | (75,337.31) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 74,637.89 | 106,481.41 | 31,843.51 |
| Үндсэн хөрөнгө | 550,873.90 | 644,095.42 | 93,221.52 |
| **Нийт хөрөнгө** | **701,349.11** | **763,101.31** | **61,752.20** |
| Өр төлбөр | 63,345.88 | 19,327.22 | (44,018.66) |
| Засгийн газрын хувь оролцоо | 638,003.23 | 743,774.09 | 105,770.86 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **701,349.11** | **763,101.31** | **61,752.20** |

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 12,024.48 мянган төгрөг болж 12,024.48 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвийн дансны үлдэгдэлтэй гарсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 79,550.6 мянган төгрөг болж, 500.0 мянган төгрөгөөр буурсан нь төлбөртэй үйлчилгээний авлага 75,337.3 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 106,481.41 мянган төгрөг болж, 31,843.51 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал 16,723.3 мянга, аж ахуйн материал 2,888.9 мянга, сэлбэг хэрэгсэл 2,890.0 мянга, түлш шатах тослох материал 8,628.2 мянга, хүнсний материал 1,158.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн, бичиг хэргийн материал 445.9 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 644,095.42 мянган төгрөг болж 93,221.52 мянган төгрөгөөр өссөн нь авто тээврийн хэрэгсэл 176,980.0 мянга, тоног төхөөрөмж 28,800.0 мянган төгрөгөөр тус тус өсч, тайлант хугацааны үндсэн хөрөнгийн элэгдэл 112,558.5 мянган төгрөг гарсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 19,327.22 мянган төгрөг болж, 44,018.66 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагад төлөх өглөг 15,206.5 мянга, ажилчидтай холбогдсон өглөг 28,812.2 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 743,774.09 мянган төгрөг болж 105,770.86 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,526,430.0 мянга, орон нутгийн төсвөөс 58,771.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд улсын төсвөөс 1,242,860.7 мянга, орон нутгийн төсвөөс 42,181.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 32 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,242,860.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 4,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 42,181.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,211,612.2 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 130.0 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 4,000.0 мянга, орон нутгийн төсвөөс 37,919.0 мянган төгрөг олгож, нийт 1,253,661.2 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,241,636.7 мянган төгрөг буюу 96.6 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл/Улсын төсөв/*

*/мянган төгрөг/*

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | Нэр | | | | |
| 1 | 80302 | Нэг иргэнд ногдох нормативаар | 960,127.1 | 949,418.9 | 10,708.2 | 98.8 |
| 2 | 81603 | үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 207,396.3 | 175,489.3 | 31,907.0 | 84.5 |
| 3 | 83603 | Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан | 79,337.3 | 78,809.5 | 527.8 | 99.3 |
| | | **ДҮН** | **1,246,860.7** | **1,203,717.7** | **43,143.0** | **96.5** |

*Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл / Орон нутгийн төсөв/*

*/мянган төгрөг/*

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | Нэр | | | | |
| 1 | 80111 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 42,181.4 | 37,919.0 | 4,262.4 | 89 |
| | | **ДҮН** | **42,181.4** | **37,919.0** | **4,262.4** | 89 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн /мянган төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Программ хангамжийн бүртгэл, тайлагнал | 0.0 | 0.0 | Санхүүгийн программыг 2008 онд 740.0 мянган төгрөгийн программ хангамж дансанд бүртгэлтэй байна. |
| 2 | Унаа хоолны хөнгөлөлт, зардлын тариф | 8,356.4 | 6,631.4 | Дотоод журамд заасны дагуу нэг хүнд 1 өдрийн 5.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна. |
| 3 | Сургалт, семинар, хурал зөвлөгөөнд зарцуулсан зардал | 0.0 | 0.0 | Тайлант онд сургалт, семинар, хурал зөвлөгөөнд зардал гараагүй байна. |
| 4 | Гадаад томилолт, арга хэмжээнд зарцуулсан зардал | 0.0 | 0.0 | Тайлант онд гадаад томилолтод зардал гараагүй байна. |
| 5 | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал | 0.0 | 0.0 | Тайлант онд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал гараагүй байна. |
| 6 | Орон тооны цомхотгол | 0.0 | 0.0 | Тайлант онд орон тооны цомхтгол хийгдээгүй байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7 | Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээлэл | 0.0 | 0.0 | Тайлант онд хэвлэл мэдээллийн байгууллагуудад төлбөр төлөөгүй байна. |

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Увс аймгийн Өндөрхангай сумын Эрүүл мэндийн төвийн тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Увс аймгийн Өндөрхангай сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бөгөөд 145,599.5 мянган төгрөгийн бараа материалын шууд худалдан авалт хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өндөрхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2026 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хооронд Шүрт хайрханы хишиг аудит ХХК-ийн аудитор С.Батсайхан гүйцэтгэж, чанарын хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нямбуу, аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өндөрхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Шүрт хайрханы хишиг аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,287,916.1 мянган 1 хувиар буюу 12,879.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг төлөвлөлтийн 80.0 хувиар буюу 10,303.3 мянган төгрөгөөр гүйцэтгэлийн шатанд шинэчлэн тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Өндөрхангай сумын Эрүүл мэндийн төв нь тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өндөрхангай сумын Эрүүл мэндийн төв нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 47 мэдээллээс хугацаа хэтрүүлж оруулсан 32, огт мэдээлээгүй 15, мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй.

#### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

| ДД | Аудитын нэр | Төрөл | Зөрчлийн утга | Шийдвэр | Өгсөн | Хэрэгжилт | Үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Өндөрхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн | Санхүү | Увс аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны 07-р сарын 03-ны өдрийн Б/40 дугаартай тушаалаар 2023 оны санхүүгийн тайлангийн дүгнэлтээр "Өөрчлөлтгүй" | Зөвлөмж | 1,467.0 | 1467.0 | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан | | дүгнэлт авсан гэж дарга, нягтлан бодогч нарт 2 сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгож, нийт 1,467.0 мянган төгрөгийн цалин илүү олгосон байна. | | | | |
| | дүн | | | | 1,467.0 | 1,467.00 | - |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 980.7 мянган төгрөгийн зөрчил[1] илэрсэнд төлбөрийн акт тогтоосон.

### 5.1. Төлбөрийн акт

1. Эрүүл мэндийн төвийн дарга Ч.Энхтуяад ээлжийн амралтын цалин болон тухайн сарын цалинг давхардуулан тооцож 980.7 мянган төгрөгийн цалинг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.2-т "Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгоно", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2 дахь "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

<u>**Шийдвэрлэсэн нь:**</u> Төлбөрийн акт тогтоосон.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Эрүүл мэндийн төвийн дарга Ч.Энхтуяад ээлжийн амралтын цалин болон тухайн сарын цалинг давхардуулан тооцож 980.7 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна. | 1 | 980.7 | 1 | 980.7 | | | | | | | | |
| Дүн | 1 | 980.7 | 1 | 980.7 | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

“ШҮРТ ХАЙРХАНЫ ХИШИГ АУДИТ” ХХК-ийн АУДИТОР /С.БАТСАЙХАН/

2026 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

**УВС АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2026 оны 02 сарын 16 өдөр — Дугаар 01/02/B2715686 УВА-2026/026/НА-СТА-ТШ3 — Улаангом

# ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Өндөрхангай сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн төвийн дарга Ч.Энхтуяад ээлжийн амралтын цалин болон тухайн сарын цалинг давхардуулан тооцож 980.7 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Илүү олгосон цалин 980,716.0 (есөн зуун наян мянга долоон зуун арван зургаан) төгрөгийг Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй Өндөрхангай сумын Эрүүл мэндийн төвийн дарга Ч.Энхтуяа, нягтлан бодогч Б.Гантогтох нараар төлүүлж, Төрийн сан дахь МХГ-ын орлогын 100015000982 тоот дансанд төвлөрүүлэх;

[1]Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг, Ө.Бадрахын гудамж, аймгийн Засаг Даргын Тамгын газрын байр, 304 тоот, Утас: 70453317

8525110018

2. Актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт[1] ирүүлэхийг Өндөрхангай сумын Засаг дарга М.Отгонбаярт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

АУДИТЫН МЕНЕЖЕР М.БАТ-АМГАЛАН

9065556 1525010041

“ШҮРТ ХАЙРХАНЫ ХИШИГ АУДИТ” ХХК-ийн
АУДИТОР С.БАТСАЙХАН